

## МОНГОЛ УЛСЫН МАЛ АЖ АХУЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

### Нэг. Ерөнхий мэдээлэл

#### 1.1. Тулгамдаж байгаа асуудал, нөхцөл байдлын дүн шинжилгээний гол үр дүн

##### 1.1.1. Удиртгал

Мал аж ахуйн салбар нь 2016 оны байдлаар ДНБ-ний 10%, нийт ажиллах хүчний 28%-ийг хангаж, ХАА-н салбарын нийт үйлдвэрлэлийн 88%, экспортын орлогын 6.6%, хөдөөгийн нийт өрхийн 56%-ийн амьжиргааны гол эх үүсвэрийг бүрдүүлж байна<sup>1</sup>.

Монгол Улсын нийт малын тоо 2017 онд 66.2 сая толгойд хүрсэн нь өмнө байгаагүй амжилт боловч бэлчээрийн доройтол, нэг малаас авах ашиг шимийн бууралт, малын өвчин, малчдын нийгмийн асуудал зэрэг тулгамдсан асуудлууд мал аж ахуйн салбарт байсаар байна.

##### 1.1.2. Бэлчээрийн доройтол

Монгол орон нь 110.5 сая га бэлчээрийн талбайтай бөгөөд 2014 оны байдлаар нийт бэлчээрийн 65% нь унаган төлөв байдлаасаа өөрчлөгдөж, доройтсон байна<sup>2</sup>. Бэлчээрийн доройтлын үндсэн шалтгаан нь эдийн засгийн эргэлтэнд удаан ордог, ашиг шим муутай хэт их малын тоо толгойн өсөлттэй холбоотой. 2017 оны малын тоо нь Монгол Улсын бэлчээрийн даацаас 25 сая гаруй хонин толгой малаар хэтэрсэн байна<sup>3</sup>. Мал сүргийн тоо бэлчээрийн даацаас хэтэрсэнээр бэлчээрийн тэжээлийн нөөц хомсдож, цаашлаад ган, зудын эрсдэлд өртөх эзэмг байдал нэмэгдэж, улмаар богино хугацаанд байгалийн гамшигт олон сая мал хорогдох нөхцөл болж байна.

Бэлчээрийн ургамал нөхөн төлжих хугацаанаас нь өмнө мал бэлчээх нь бэлчээр доройтох үндсэн шалтгаан болохоос гадна, малчдын отор, нүүдэл хийх зай багасах, нүүдэл хийх тоо цөөрөх зэрэг шалтгаанаар алслагдсан хязгаар нутгийн бэлчээрийг зохих түвшинд ашиглахгүй байна. Усны эх ундрага, гол, мөрөн, нуур, цөөрөм, булаг шанд мөн сум, аймгийн төв газар малын тоо хэт олширсноор тэр хавийн бэлчээр мэдэгдэхүйц доройтож, нөхөн сэргэх боломжоо алдаж байна.

Монгол Улсад бэлчээрийн асуудлыг “Газрын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад оруулсан байдаг боловч тус асуудлыг цогцоор нь буюу нэгдмэл байдлаар зохицуулсан хууль эрх зүйн баримт бичиг, хариуцсан төрийн нэгдсэн институт байхгүйн улмаас бодлогын нэгдмэл байдал алдагдаж, бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлж чадахгүй байна. Тухайлбал газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, бэлчээр ашиглалтын төлөвлөгөө батлах, хэрэгжүүлэх үүрэг нь орон нутгийн өөрөө удирдах байгууллагын газрын харилцаа хариуцсан нэгжид, цаашилбал газрын кадастр, зураг зүйн асуудал нь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт, бэлчээрийн төлөв байдлыг үнэлэх асуудал нь Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнд, мөн отрын бэлчээрийн асуудал нь ХХААХҮЯ-д гэх мэтээр хуваарилагдсан байдаг.

##### 1.1.3. Малын ашиг шим, салбарын эдийн засгийн үр ашгийн бууралт

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн уламжлалт хандлага нь "өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл" явуулах буюу малын тоог өсгөхөд чиглэгдэж, харин малын чанар буюу нэг малаас авах ашиг шимийг өсгөхөд чиглэгдэхгүй байна. Монгол Улсын малын тоо толгой сүүлийн жилүүдэд хурдацтай өсч байгаа нь эдийн засгийн өсөлтөд сайнаар нөлөөлсөн боловч нэг малаас авах ашиг шим тэр хэмжээгээр өсч чадаагүй байна. Тухайлбал 1989 онд нэг малаас авах нэмүү өртөг 37.5 мянган төгрөг байсан бол 2014 онд энэ үзүүлэлт бараг өөрчлөгдөөгүй<sup>4</sup>, харин ч буурч байна<sup>5</sup>. 2014 онд хийсэн судалгаагаар өнгөрсөн 10 жилд

<sup>1</sup> ҮСХ (2017) Монгол улсын статистикийн эмхэтгэл-2016

<sup>2</sup> Ногоон алт төсөл (2015) Монгол орны бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайлан

<sup>3</sup> ХХААХҮЯ (2018.05.01) Бэлчээрийн тухай хуулийн төслийн танилцуулга

<sup>4</sup> <https://www.mongolbank.mn/documents/tovhimol/group10/10-19.pdf>

<sup>5</sup> Малчид, орон нутгийн удирдлагатай хийсэн ярилцлага.

дундаж хонины амьдын жин 1-2 кг-аар, харин үхрийн амьдын жин 30 орчим кг-аар буурсан байна<sup>6</sup>. Малын ашиг шим буурч байгааг статистик тоо мэдээ нотолж байна. Тухайлбал 1990 онд 6.85 сая толгой бог мал нядлан 132.3 мянган тонн махыг бэлтгэсэн бөгөөд бог малын гулуузны жин 19.3 КГ байсан. Харин 2016 онд 11.6 сая толгой бог мал нядлан 193.1 мянган тонн мах бэлтгэсэн бөгөөд нэг бог малын гулуузны жин 16.6 КГ болж 13.9%-иар буурчээ.

Улсын дунджаар 2010 онд нутгийн Монгол үнээний сүүний өдрийн дундаж гарц 2.6 литр, нэг жилд саалинд хамрагдах хугацаа 6.7 сар, саалинд хамрагдалтын хувь 92.6% байсан бол 2015 онд сүүний гарц 2.1 литр, саалинд хамрагдах хугацаа 5.9 сар, саалинд хамрагдалтын хувь 86.4% болж тус тус буурсан байна<sup>7</sup>. Мөн 1998 онд нас гүйцсэн тэмээний ноосны гарц 4,540 грамм, хонины уртын ноосны гарц 1,446 грамм байдаг байсан бол 2015 онд тэмээнийх 4,381 грамм, хониных 1,103 грамм болж тус тус буурчээ.

Малын ашиг шим буурахад нэг талаас бэлчээрийн доройтол, хуурайшилт, цөлжилт, гол, мөрөн, нуурын усны хомсдол, уур амьсгалын өөрчлөлт зэрэг байгалийн хүчин зүйлс нөлөөлсөн, нөгөө талаас малын эрүүл мэнд доройтсоноос үүдсэн малын хорогдол, хээл хаялт ихэссэн, мал үржил, селекцийн ажил зохицуулалтгүй хийгдэх, малын отор нүүдэл багассан зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн.

Цаашлаад таван хошуу малын махны экспорт хангалттай хийгдэж чадахгүй байгаа нь малыг эргэлтэнд оруулахад саад болж байна. Монгол Улсаас мах экспортлоход учирч байгаа хамгийн том саад бэрхшээл нь малын халдварт өвчний дэгдэлт бөгөөд олон улсын малын эрүүл мэндийн стандарт шаардлагыг хангаж чадахгүй хэвээр байсаар байна. Монгол Улсад малын гаралтай халдварт өвчин гарч байгаа хэдий ч малын өвчингүй, тайван бүс нутгийг зарлах, өвчингүй бүсийн малын гарал, үүслийг тодорхойлох, мөшгих тогтолцоог бий болгох ажил хангалттай түвшинд хийгдээгүй байна.

Мал аж ахуй эрхлэгчдийн эдийн засгийн ашиг буурах дараагийн нэг шалтгаан нь мал аж ахуйн зөвлөх үйлчилгээ буюу “Экстэйншиний зөвлөх үйлчилгээ”-ний хүртээмж бага, малчдын дунд энэ талын үйлчилгээний ач холбогдлын талаар ойлгох ойлголт сул байгаатай холбоотой. Малын өвчин, үржил селекцийн ажил, ган, зуд, отор, нүүдэл гэх мэт малын ашиг шим, малын тоо, толгойг бууруулах хүчин зүйлсийн сөрөг нөлөөг бууруулах, газар дээр нь шуурхай арга хэмжээ авах, малчдад энэ талын мэдлэг, мэдээллийг тархаах зэрэг ажлыг экстэйншиний үйлчилгээнд хамруулан авч үзэх ёстой.

#### **1.1.4. Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал**

Мал аж ахуйн салбар нь хүний эрүүл мэнд, дэлхийн хүнсний болон шим тэжээлийн аюулгүй байдалд чухал нөлөөтэй. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” зорилтын хэрэгжилтийг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалахад малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал чухал юм.

Малын эрүүл мэндийг дээшлүүлэхэд санхүүжилт дутмаг байна. Тухайлбал, малын өвчин гарахаас урьдчилан сэргийлэх, малын өвчинтэй тэмцэх зардал хангалтгүй байна. Мал эмнэлгийн үйлчилгээ явуулахад шаардагдах эм тариа, шатахууны хүрэлцээ, хангамж сул байна. Малчид мал эмнэлгийн үйлчилгээг авах сонирхол өндөр байдаг, гэвч энэ төрлийн үйлчилгээний хөлс өндөр байна. Тухайлбал нэг хонинд жилд зарцуулах мал эмнэлгийн үйлчилгээний зардал ойролцоогоор 50 мянган төгрөг, зарим тохиолдолд түүнээс дээш байна, өөрөөр хэлбэл энэ өндөр зардлыг төлөөд цаана нь ашиг олох боломж малчдад хомс байдаг<sup>8</sup>.

Мөн малчид малын эрүүл мэндийн үйлчилгээг дур мэдэн өөрсдөө хийх, мэргэжлийн бус аргаар явуулах явдал гарсаар байна. Тухайлбал, малын эмийн сангаас өөрсдөө эм, тариа авч малд тарих явдал хөдөөгийн малчдын дунд их байна.

Малын тоо толгой өссөнтэй холбоотойгоор малын нягтрал ихсэх, мөн өвчтэй малын шилжих хөдөлгөөн нэмэгдэх зэрэг шалтгааны улмаас малын өвчин тархах эрсдэл нэмэгдэж

<sup>6</sup> <http://old.eagle.mn/content/read/14408.htm>

<sup>7</sup> ҮСХ (2017) Хөдөө аж ахуйн түүвэр судалгаа-2015: Нэгдсэн үр дүн, [http://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Agricultural\\_sample\\_surveys\\_2016\\_mn.pdf&ln=Mn](http://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Agricultural_sample_surveys_2016_mn.pdf&ln=Mn)

<sup>8</sup> Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбооны захирал Н.Ганхуяг хийсэн ярилцлага.

байна. Тухайлбал 2016 онд давхардсан тоогоор 598 суманд халдварт өвчин гарсан бөгөөд энэ нь 2007 оны үзүүлэлтээс даруй 1.9 дахин их байна. Гэтэл 2016 оны малын тоо нь 2007 оныхоос 1.5 дахин их байна<sup>9</sup>. Өөрөөр хэлбэл, халдварт өвчин гарсан сумын тоо (давхардсан тоогоор) малын тооны өсөлтөөс илүү хурдацтай өсчээ.

Нийт мал сүргийн хэдэн хувь нь эрүүл, хэдэн хувь нь эрүүл бүсэд үйлдвэрлэгдсэн болохыг нотлох бүртгэл мэдээллийн нэгдсэн систем Монгол Улсад байхгүй байна. Үүнээс үүдэн олон улсын зах зээлд малын гаралтай бүтээгдэхүүнээ эрүүл, баталгаатай гэдгийг баталж чадахгүй байгаа бөгөөд цаашид дэлхийн зах зээлд хангалттай хэмжээгээр борлуулж чадахгүй байна. Үүнээс үүдэн мал үнэгүйдэх, улмаар малаа нядлах, мах борлуулах сонирхол малчдад бага байна.

Малын эрүүл мэндий тухай хуулинд мал эмнэлгийн асуудлыг босоо тогтолцоотой болгохоор тусгасан, гэхдээ энэ хууль хэрэгжиж эхэлсний дараа үр дүн нь мэдэгдэх болно. Хууль амжилттай хэрэгжихэд учирч буй саад бэрхшээл нь нэгдүгээрт тус хуулийн үндсэн зарчмыг төрийн албан хаагчид, малын эмч нарын дунд ойлголт сул байх, хоёрдугаарт мал эмнэлгийн шинэ стандарт боловсруулах, холбогдох журамд өөрчлөлт оруулах ажил удаашралтай, энэ ажлыг хийх мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байх, гуравдугаарт малын эмийн бизнес эрхлэгчдийн зүгээс эсэргүүцэл үзүүлэх, дөрөвдүгээрт махны экспортыг нэмэгдүүлж малыг тоог бууруулах зорилго тависан болон олон улсын зах зээл хангалттай хэмжээгээр тэлэхгүй байх гэх мэт багтана.

Малын өвчин оношлох, өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг хийх зардлыг төр санхүүжүүлэхгүй байгаагаар малчид малын өвчин оношлох үүрэг хүлээдэг болсонтой холбоотойгоор малын өвчний гаралт ихсэх, улмаар халдварлах нөхцөл бүрдэж байна. Одоогийн тогтолцоогоор бол малын өвчин гарсны дараа түүнийг эмчлэх, ариутгал устгал хийх ажил өрнөж түүнд зарцуулах зардал их байгаа болохоос биш малын өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг санхүүжүүлэх тогтолцоо бүрдээгүй байна. Үүний шалтгаан нь нэг малын эрүүл мэндийг хамгаалахад шаардагдах санхүүжилтийн хэмжээ бага байгаагаар холбоотой. Тухайлбал 1989 онд нэг малын эмчид 13.5 мянган толгой мал ноддог байсан бол 2017 онд энэ үзүүлэлт 39.2 мянган толгой мал болж 3 дахин өссөн байна<sup>10</sup>.

Малын эмчийн мэргэжлээр их, дээд сургууль төгссөн төгсөгчид орон нутагт эзэмшсэн мэргэжлээрээ ажиллахгүй байна. Тухайлбал 2011 онд ХААИС-ийг “Малын их эмч” мэргэжлээр нийт 119 оюутан төгссөн бөгөөд тэдгээрийн 74 нь буюу 62.2% нь 2015 онд мэргэжлээрээ ажиллаж байжээ<sup>11</sup>. Үүний шалтгаан нь орон нутагт ажлын байр хомс, цалин бага, ажиллах орчин тааруу байгаагаар холбоотой. тухайлбал малын үзлэг, оношилгоо, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхэд газар нутаг том, дэд бүтэц сул хөгжсөн, байгаль цаг уурын хатуу ширүүн нөхцөлд үйл ажиллагаа явуулах шаардлагатай болдог.

### **1.1.5. Малын үржил, селекцийн ажил**

Судлаачид мал нядлах нас хойшилж, хөгшрүүлж байж нядлах болсон гэж үзэж байна, тиймээс хэдий тийм боловч гулуузны гарц багасч байгаа нь малын үржил, селекцийн ажил хангалттай түвшинд хийгдэхгүй байгааг харуулж байна. 1990 онд нийт мал сүргийн 29.5%-ийг нядалсан байдаг, гэтэл 2016 онд энэ үзүүлэлт 20.6% болж буурсан нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн эргэлт удаашрах, малын тоо өсөхөд нөлөөлж байна.

1992 онд батлагдсан “Малын удмын сан, эрүүл мэндийн тухай” хуульд малын эрүүл мэнд, малын үржлийн ажлыг хамтатган оруулсантай холбоотойгоор малын үржлийн ажлын ач холбогдол багасч, мал зүйч, малын зоо техникчийн эрэлт буурч, боловсон хүчний чадавх суларсан, улмаар Монгол малын үүлдэрлэг байдал багасч, эрлийзжилт нэмэгдэж, тэсвэр хатуужил нь буурч, бие нь давжааран, сүргийн бүтэц алдагдахад хүрсэн<sup>12</sup>. 1989 онд нэг

<sup>9</sup> ҮСХ (2017) Монгол улсын статистикийн эмхэтгэл-2016

<sup>10</sup> ҮСХ (1992) Монгол Улсын 1991 оны мал тооллого, <http://www.1212.mn/BookLibraryDownload.aspx?url=livestock1991.pdf&ln=Mn>, Мал эмнэлэг үржлийн газар (2017) Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мал эмнэлэг, үржлийн газрын 2017 оны үйл ажиллагааны тайлан, хуудас 6

<sup>11</sup> ХААИС-ийн Мал эмнэлгийн сургууль (2015) ХААИС-Мал эмнэлгийн сургуулийн 1983-2014 оны төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, олон нийтэд хэвлэгдэн тараадаагүй тоо мэдээ

<sup>12</sup> Мал эмнэлэг үржлийн газар (2017) Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мал эмнэлэг, үржлийн газрын 2017 оны үйл ажиллагааны тайлан

малзүйчид 20.3 мянган толгой хээлтэгч мал ногдож байсан бол 2017 онд энэ үзүүлэлт 67.7 мянган толгой хээлтэгч мал болж даруй 3.3 дахин өсчээ.

Монгол орны уур амьсгалд дасан зохицсон, мах, сүү, үс, ноосны ашиг шим өндөртэй малын үржлийн ажил зохион байгуулалттай хийгдэхгүй, малчид хоорондоо тохирлцох замаар хийгдэж байна. Мал үржүүлгийн ажил хуваарийн дагуу хийгддэггүй, цөм сүрэг өсгөх, зохиомол хээлтүүлэг хийх боломж нөхцөл байхгүй гэх мэт олон шалтгааны улмаас хөдөө орон нутагт малын үржил, селекцийн ажил үр дүн муутай байна.

Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн нь түүний чанарын үзүүлэлт (махны зөөлөн чанар, өөх махны харьцаа гэх мэт, ноос, ноолуурын диаметр, урт гэх мэт)-ээс үл хамааран зах зээлд тогтсон нэг үнээр борлогддог, энэ нь бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэхэд учирч буй гол саад бэрхшээл болж байна. Өөрөөр хэлбэл чанарын ялгаатай байдлаас хамааран ялгавартай үнийн тогтолцоо байхгүйгээс малчид сайн чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ашиг шим сайтай мал өсгөх, түүнд зориулан малын үржил, селекцийн үйл ажиллагаа явуулах сонирхол бага байна.

#### **1.1.6. Малчдын залгамж халаа**

1990 онд 15-34 насны малчид нийт малчдын 55.7%-ийг эзэлдэг байсан бол 2016 онд энэ үзүүлэлт 34.8% болж 37.5%-иар буурсан байна<sup>13</sup>. Мал аж ахуйн салбарт тулгамдаж байгаа асуудлууд дотроос малчдын залгамж халаа алдагдах, залуучууд хот, суурин газарт шилжин сууриших явдал ихээр гарч байгаа асуудал нь цаашид тус салбарт ажиллах ажиллах хүчин дутагдах, улмаар уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлөх үр дагавартай. Хот руу шилжин суурьших гол шалтгаан нь тэнд ажлын байр олдох боломж болон сарын орлого өндөр байдагтай холбоотой. Тухайлбал, 2017 оны байдлаар нэг өрхийн сарын дундаж орлого хотод 1.1 сая төгрөг, хөдөөд 896.4 мянган төгрөг байсан<sup>14</sup>. Эндээс харвал хөдөөгийн нэг өрхийн орлого хотынхоос 24.2%-иар бага байгаа байна.

Мал хариулан аж ахуй эрхлэх сонирхол хөдөө, орон нутгийн залуу хүмүүст бага байгаа нь хэд хэдэн шалтгаантай. Үүнд тухайлбал: Одоо үеийн малчид өөрсдийн үр хүүхдээ малчин болгох сонирхол буурсан, тэд мал аж ахуй эрхлэх нь маш хэцүү, хүнд хүчир ажил гэж үзэх тохиолдол байдаг, тиймээс хүүхдүүдээ хот суурин газарт сургуульд явуулах сонирхолтой бөгөөд сурах чиглэл нь мал аж ахуйтай холбоо багатай мэргэжил сонгуулах сонирхол ихтэй байна. Мөн залуучууд хөдөө, орон нутагт мал хариулах нь орчин үеийн амьдралын хэв маяг биш, улмаар нийгэм соёлын хөгжлөөс хоцрогдох талтай гэх үзэл давамгайлж байна. Үүний цаад шалтгаан нь одоогийн нийгмийн тогтолцооны хэв маяг, мөн хоттой харьцуулахад хөдөө, орон нутгийн хөгжил сул хөгжсөн, мөн мал аж ахуйн салбарт ажиллагсдын орлого, амьжиргааны түвшин бусад салбартай харьцуулахад бага байгаатай холбоотой.

Орон нутагт залуу эрэгтэй малчид олширч, тэдэнтэй гэрлэх эмэгтэйчүүд цөөрч байна. Энэ нь малчид эмэгтэй хүүхдийн боловсролд эрэгтэй хүүхдийнхээс илүүтэйгээр анхаарах, эрэгтэй хүүхдээг мал аж ахуйгаа залгамжлуулах сонирхолтой байдагтай холбоотой. 2009 оны судалгаанаас харахад сургууль завсардсан 8-15 насны хүүхдүүдийн 60 хувь нь ядуу малчин айлын хөвгүүд эзэлж байв<sup>15</sup>.

#### **1.1.7. Малчдын эрүүл мэнд, нийгмийн асуудлууд**

Мал аж ахуй эрхлэн амьдардаг малчдын ажлын орчин нөхцөл нь байгаль орчны хатуу ширүүн уур амьсгалаас хамаарал ихтэй, тийм ч учраас малчдын дундаж наслалт хот суурин газрын хүмүүсийн дундаж наслалтаас доогуур байдаг<sup>16</sup>. Малчдад тохиолдох зонхилох өвчинд ходоод, элэг, цөсний өвчлөл орж байна. 2010 онд хот, суурин газарт амьдардаг 5 хүртэлх насны хүүхдүүдийн 12.7% нь өсөлтийн хоцролттой байсан бол хөдөө

<sup>13</sup> УСХ (2001, 2017) Монгол улсын статистикийн эмхэтгэл-2000, 2016 дээр үндэслэн тооцсон тооцоолол.

<sup>14</sup> [http://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=HSES\\_tan\\_2017\\_4q.pdf&ln=Mn](http://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=HSES_tan_2017_4q.pdf&ln=Mn)

<sup>15</sup> Штайнер-Хасми, Гита, Амгаабазар Гэрэлмаа (2009) “Монголын боловсролын салбарын чанар, тэгш байдал”, Чанар, Тэгш байдлыг бий болгоход тулгарч буй бэрхшээл, ололт амжилт - Кэйс судалгаа, pp. 409-414, UNESCO

[https://www.eda.admin.ch/dam/countries/countries-content/mongolia/en/2015-Gender-Overview-%20Desk-Study-Mongolia\\_MN.pdf](https://www.eda.admin.ch/dam/countries/countries-content/mongolia/en/2015-Gender-Overview-%20Desk-Study-Mongolia_MN.pdf)

<sup>16</sup> <http://www.parliament.mn/n/5epo>

орон нутагт энэ үзүүлэлт 20.3% байжээ<sup>17</sup>. 2008 оны судалгаагаар эхийн эндэгдэлд орсон эмэгтэйчүүдийн 40 орчим хувь нь эмнэлгийн үйлчилгээ хангалтгүй алслагдсан бүс нутгийн малчин эмэгтэйчүүд байжээ<sup>18</sup>. Учир нь хөдөөгийн нийт хүн амын 67 хувь нь сумын эмнэлгээс 50-80 км зайд амьдардаг байсан байна<sup>19</sup>.

2013 оны байдлаар хотод амьдардаг хүмүүсийн 62.5% нь бүрэн дундаас дээш боловсролтой байсан бол энэ үзүүлэлт хөдөөд 30.9% байжээ<sup>20</sup>. Эндээс үзвэл хөдөө орон нутгийн малчдын боловсролын түвшин хотын хүн амаас доогуур байгааг харуулж байна.

Малын тоо толгой хурдацтай өсч байгаа боловч малын тоо толгойн ихэнх нь цөөн хэдэн хүний өмчлөлд байдаг. Тухайлбал, 2016 оны байдлаар 200-аас доош толгой малтай малчин өрх нийт малчин өрхийн 43%-ийг эзлэх бөгөөд тэдний мал нь нийт мал сүргийн дөнгөж 12%-ийг эзэлж байна (мал бүхий өрхийн малыг оролцуулж тооцоогүй)<sup>21</sup>.

2014 онд хөдөөгийн ядуурлын түвшин 26.4% байснаа, 2016 онд 39.4% болж өссөн, мөн хөдөөгийн ядуурал хотынхоос байнга өндөр байсаар ирсэн<sup>22</sup>. 2016 оны байдлаар хөдөөгийн хүн амын 67.2% нь малтай, тэдгээрийн 33.4% нь ядуу байна<sup>23</sup>. 2015 онд нийт малчдын ойролцоогоор 9.7% нь, 2016 онд 19.3% нь нийгмийн даатгал төлсөн байв<sup>24</sup>.

2016 онд малчдын нийгмийн даатгал төлөлт өссөн шалтгаан нь малчдын тэтгэвэр тогтоох насыг бууруулах эрх зүйн зохицуулалт хийгдсэнтэй холбоотой. Гэвч нь бусад салбарт ажилладаг хүмүүстэй харьцуулахад малчдын нийгмийн даатгал төлөлт хангалтгүй байна. Нийгмийн даатгал төлөлтийн хувь бага учраас тэдний авч байгаа тэтгэврийн хэмжээ бусад тэтгэвэр авагчдаас харьцангуй доогуур буюу ойролцоогоор 258.2 мянган төгрөг байна<sup>25</sup>.

Малчдад тулгарч байгаа олон асуудлуудын нэг нь бэлэн мөнгөний хэрэгцээгээ жилийн турш хангах боломж тааруу байгаа явдал юм. Бэлэн мөнгөний гол эх үүсвэр болсон ямаа сүргээ хэт өсгөн үржүүлсэн нь бэлчээрийн доройтолын шалтгаануудын нэг гэж үздэг ба энэ нь малчдын амьжиргааны баталгаатай, тогтвортой байдлыг алдагдуулах эрсдэлтэй юм. Малчид бэлэн мөнгөний дутагдалаа банкнаас өндөр хүүтэй зээл авч нөхдөг ба үүнийг хавар ноолуур гарах үеэр нөхөн төлдөг. Малчин өрх бэлэн мөнгөний гачигдалд байдаг учраас нийгмийн даатгалын төлбөр бага төлдөг, улмаар тэтгэвэрт гарах үед тэтгэврийн хэмжээ хамгийн багаар тогтоогддог.

Монгол улсын мал аж ахуйн салбарт тулгамдаад буй дээрх асуудлуудыг шийдвэрлэх, салбарын эдийн засаг, нийгэм соёл, байгаль орчинд үзүүлэх сайн нөлөөг дэмжсэн тогтвортой байдлыг бий болгохоор мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийг боловсруулсан болно.

## **1.2. Хөтөлбөр боловсруулах эрх зүйн үндэслэл**

“Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр” (2.26, 2.28, 2.29, 2.36, 2.38 дахь заалтууд), “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого” (1.6, 2.3, 2.4, 2.5 дахь заалтууд), “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого” (3.1.5, 3.1.6 дахь заалтууд), “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” (3.3, 3.4 дахь заалтууд), “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” (Зорилт 1, 3, 4), “Монгол улсын Засгийн газрын гурван тулгуурт хөгжлийн бодлого” (Зорилт 1, 2, 14, 19) зэрэг бодлогын баримт бичгүүдэд тулгуурлан “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай Монгол улсын хууль”-ийн дагуу энэхүү хөтөлбөрийг боловсруулсан болно.

<sup>17</sup>[http://www.1212.mn/tables.aspx?tbl\\_id=DT\\_NS0\\_2800\\_067V1&Poverty\\_60\\_select\\_all=0&Poverty\\_60SingleSelect=\\_1\\_2&YearY\\_select\\_all=0&YearYSingleSelect=\\_2010\\_2000&viewtype=table](http://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_2800_067V1&Poverty_60_select_all=0&Poverty_60SingleSelect=_1_2&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2010_2000&viewtype=table)

<sup>18</sup> [https://www.unicef.org/mongolia/Mongolian\\_version\\_of\\_SITAN.pdf](https://www.unicef.org/mongolia/Mongolian_version_of_SITAN.pdf)

<sup>19</sup> [https://www.unicef.org/mongolia/Mongolian\\_version\\_of\\_SITAN.pdf](https://www.unicef.org/mongolia/Mongolian_version_of_SITAN.pdf)

<sup>20</sup> ҮСХ (2014) Монгол Улс: Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа – 2013, <http://www.ulaantuuz.mn/wp-content/uploads/2016/05/SISS2013.pdf>

<sup>21</sup> ҮСХ (2017) Монгол улсын статистикийн эмхэтгэл-2016 дээр үндэслэн тооцсон тооцоолол.

<sup>22</sup> ҮСХ (2017) Ядуурлын дүр төрх-2016 (Өрхийн нийгэм, эдийн засгийн 2016 оны судалгааны үр дүн)

<sup>23</sup> ҮСХ (2017) Ядуурлын дүр төрх-2016 (Өрхийн нийгэм, эдийн засгийн 2016 оны судалгааны үр дүн)

<sup>24</sup> [http://www.1212.mn/BookLibraryDownload.aspx?url=social\\_welfare\\_2016.pdf&ln=Mn](http://www.1212.mn/BookLibraryDownload.aspx?url=social_welfare_2016.pdf&ln=Mn)

<sup>25</sup> <http://erennews.mn/index.php?view=article&type=item&val=4630>

Мөн энэхүү хөтөлбөр нь Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Монгол мал хөтөлбөр”, “Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөр”, “Үйлдвэржилт 21-100 үндэсний хөтөлбөр”, “Ноолуур үндэсний хөтөлбөр”-тэй уялдаж байгаа болно.

1.3. Хөтөлбөрийн хамрах хүрээ, үндсэн зарчим

1.3.1. Бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох,

1.3.2. Мал аж ахуйн салбарын эдийн засгийн засгийн үр ашгийг дээшлүүлэх,

1.3.3. Малын эрүүл мэнд, хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах,

1.3.4. Хөдөөгийн нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг сайжруулах,

1.3.5. Хамтын ажиллагаа, оролцоог дээшлүүлэх.

### **Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт**

2.1. Монгол Улсын мал аж ахуйн салбарын онцлогт тулгуурлан тус салбарын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах, бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх, нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг сайжруулах, талуудын хамтын ажиллагаа, оролцоог хангахад хөтөлбөрийн зорилго оршино.

**2.2. Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:**

2.2.1 Бэлчээр, усны нөөц баялгийг зохистой, хариуцлагатай ашиглах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох, түүний сөрөг нөлөөг бууруулахад хувь нэмэр оруулах,

2.2.2 Үнэ цэнийн сүлжээнд мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх,

2.2.3 Малын эрүүл мэндийн үйлчилгээ, үржил селекци, хүнсний хангамж, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах,

2.2.4 Хөдөөгийн ядуурал, ажилгүйдэл, орлогын тэгш бус байдал бууруулах, нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах,

2.2.5 Төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллага, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага, малчдын бүлэг, нөхөрлөл, хоршоо, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг бүх түвшинд хөгжүүлэх

### **Гурав. Хөтөлбөр хэрэгжүүлэх үе шат**

3.1. Хөтөлбөрийг 2018-2030 онуудад 3 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

3.1.1. Нэгдүгээр үе шат: 2018-2021 он

3.1.2. Хоёрдугаар үе шат: 2021-2025 он

3.1.3. Гуравдугаар үе шат: 2025-2030

### **Дөрөв. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ**

4. Хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ, Үүнд:

4.1. Хөтөлбөрийн 2.2.1-д заасан зорилтын хүрээнд:

- Бэлчээрийн менежментийг байгаль, цаг уурын өөрчлөлт, улсын нийгэм засгийн хөгжилтэй уялдуулан ашиглалт хамгаалалтыг сайжруулах эрх зүйн орчинг боловсруулж, батлуулах,

- Бэлчээрийн асуудал хариуцсан нэгжийг төрийн захиргааны төв байгууллагад бий болгох,

- Бэлчээрийн чиглэлээр дагнасан мэргэжилтнийг сум орон нутагт ажилуулах.

- Бэлчээрийн төлбөрт суурилсан ”тогтвортой мал аж ахуйн үндэсний сан”-г бий болгож бэлчээр, мал, малчдын асуудлыг шийдвэрлэх болон орон нутгийн хөгжлийг дэмжихэд зарцуулах,

- Бэлчээрийн менежментийг тухайн бүс нутгийн онцлог, газар зүйн байршил, малын тоо, бэлчээрийн талхагдал, ургамлын бүлгэмдэл зэрэг олон хүчин зүйлээс хамааруулан зохион байгуулах,

#### 4.2. Хөтөлбөрийн 2.2.2-т заасан зорилтын хүрээнд:

- Мал болон мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах, олон улсын зах зээлтэй холбох,

- Мал аж ахуйн үйлдвэрлэлд технологийн дэвшил ашиглах, түгээх явдлыг урамшуулан дэмжих,

- Малчдыг чанартай, бэлчээрийн даацад тохирсон тооны малтай байхыг дэмжсэн бодлого хэрэгжүүлэх,

- Мал аж ахуйн тогтвортой байдлын оновчлолын загварыг боловсруулж бодлого боловсруулахад ашиглах.

#### 4.3. Хөтөлбөрийн 2.2.3-т заасан зорилтын хүрээнд:

- Мал эмнэлэгийн үйлчилгээг улсын хэмжээнд нэгдсэн жишгийн дагуу үзүүлдэг систем бий болгож, мал амьтны өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэвшил болгох,

- Малын ашиг шимийн түвшинг бүсчилэн тогтоож, бүс нутагт тохирсон малыг төрөлжүүлэн үржүүлэх, үржил селекцийн ажлыг зорилтот зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн явуулах

- Мал, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мөшгин тандах системийг бий болгож хөгжүүлэх,

#### 4.4. Хөтөлбөрийн 2.2.4-т заасан зорилтын хүрээнд:

- Орон нутагт ажиллаж буй мал аж ахуйн мэргэжилтнүүдийн чадавхийг сайжруулах сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, тогтмолжуулах,

- Шинээр бэлтгэгдэн гарч буй залуу боловсон хүчнийг орон нутагт ажиллах явдлыг урамшуулах, суралцах хугацаанд нь тэтгэлэг олгох,

- Малчдад нийгмийн халамжийн системийг ойртуулах, орчин үеийн мэдлэгтэй, мэдээлэлтэй малчин болж хөгжихөд нь мэдээлэл, сургалтаар хангах,

- Залуу малчдыг туршлагатай малчдаас суралцах, орчин үеийн боловсрол эзэмшүүлэхэд анхаарч ажиллах, зайны сургалт болон бусад орчин үеийн сургалтын арга хэрэгсэл ашиглах,

- Малчид, залуу малчдад зориулсан сургалтыг үзүүлэх сургалт, туршлага судлах зэрэг дадлагжих сургалтын хэлбэрээр зохион байгуулах,

- Малчдын амьжиргааны тэгш бус байдлыг бууруулах, чинээлэг дунджийг бий болгоход чиглэсэн бодлого боловсруулах,

- Туслах малчны ажлын байрыг баталгаажуулж, нэмэгдүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх.

#### 4.5. Хөтөлбөрийн 2.2.5-д заасан зорилтын хүрээнд:

- Мал аж ахуйн салбарын хөгжилд оролцогч талуудын оролцоог сайжруулах замаар тухайн салбарт хийх хөрөнгө оруулалтыг татаж харилцан ашигтай хамтран ажиллах системийг бий болгох,

- Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийн хэрэгжилтийг хянах үнэлэхэд мэдээллийн технологи, удирдлагын мэдээллийн системийг ашиглах, “мал аж ахуйн мэдээлэл, шинжилгээний нэгдсэн сүлжээ”-г бий болгох,

- Залуу үеийн мал аж ахуйн салбарт ажиллах сонирхолыг урамшуулахад оролцогч талуудын хамтын ажиллагааг ашиглах,

- Мал аж ахуйн салбарын бизнес, хувийн хэвшлийг дэмжих,

- Дотоодод үйлдвэрлэсэн мал аж ахуйн гаралтай түүхий эдийг үйлдвэрлэлд ашиглах, бүтээгдэхүүнийг хэрэглэх сонирхлыг урамшуулах,

- Мал аж ахуйн салбарын үнэ цэнэ, ач холбогдлыг олон нийтэд түгээн сурталчлах.

- Мал аж ахуйн салбарын экстэйшиний үйлчилгээг оролцогч талуудад тулгуурлан хүргэх тогтолцоог бүрдүүлэх

### Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, түүний үр нөлөө, шалгуур үзүүлэлтүүд

5.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, энэ хүрээнд хөтөлбөрийн 1.2-д дурдсан бодлого, хөтөлбөрүүд болон Газар тариалангийн бүсэд сүүний үхрийн эрчимжсэн аж ахуй байгуулах төсөл, Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, махны хадгалалт, борлуулалтын цогцолбор төв байгуулах төсөл, Махны үйлдвэрт суурилсан жишиг кластерийн төсөл, Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк төсөл, Малчдын орон сууц үйлдвэрлэлийн төсөл зэрэг тэргүүн ээлжинд хэрэгжих хөтөлбөр, төслүүдийг дэмжиж, уялдааг хангаж ажиллана.

5.2. Хөтөлбөрийг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ хийж үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (Он)	Зорилтот түвшин		Мэдээллийн эх сурвалж
				2025 он	2030 он	
<b>Нэгдүгээр зорилт: Үнэ цэнийн сүлжээнд мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх,</b>						
1	Нэг хүнд ногдох мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн аргаар тооцсон	сая төгрөг	1.12 (2016 он)	1.2	1.5	ҮСХ (2018) Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, www.1212.mn
2	Нэг малчин өрхөд ногдох мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн аргаар тооцсон	сая төгрөг	21.76 (2016 он)	30	35	ҮСХ (2018) Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, www.1212.mn
3	Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт <sup>26</sup>	сая ам.доллар	361.4 (2016 он)	400	500	ГЕГ (2018) Гадаад Худалдааны Барааны Статистик Мэдээлэл, ҮСХ (2017) Хөдөө аж ахуйн салбар-2016, хуудас 14 <sup>27</sup>
4	Нэг мал зүйчид ногдох хээлтэгч малын тоо	мянган толгой хээлтэгч мал	67.7 (2017 он)	39.6	39.6 <sup>28</sup>	Мал эмнэлэг үржлийн газар (2017) Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мал эмнэлэг, үржлийн газрын 2017 оны үйл ажиллагааны тайлан
<b>Хоёрдугаар зорилт: Малын эрүүл мэндийн үйлчилгээ, хүнсний хангамж, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах,</b>						
4	Нэг хүнд сард ногдох мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ	жишсэн хүн, кг				ҮСХ (2018) Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, www.1212.mn

<sup>26</sup> Үүнд: 1) Мал, амьтад тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн, 2) Мал, амьтан болон ургамлын гаралтай өөх, тос, 3) Түүхийн болон боловруулсан арьс шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл, 4) Нэхмэл, нэхмэлийн бүтээгдэхүүн гэсэн ангиллын бүтээгдэхүүнүүд орно.

<sup>27</sup> <http://www.1212.mn/BookLibraryDownload.aspx?url=XAA-2016.pdf&ln=Mn>

<sup>28</sup> “Малын генетик нөөцийн тухай” хуулийг хэрэгжүүлснээр бүх суманд 1-2 нэгж шинээр бий болж, мал зүйчдийн тоо өсч, улмаар 1 малзүйчид 39.6 мянган хээлтэгч мал ногдоно (Мал эмнэлэг үржлийн газар, 2017).



	3.1 Мах, махан бүтээгдэхүүн маханд шилжүүлснээр					
	3.1.1 Улсын дундаж		8.6 (2017 он)	10	11	
	3.1.1 Хот		6.9 (2017 он)	8	9	
	3.1.1 Хөдөө		10.7 (2017 он)	11	12	
	3.2 Сүү, сүүн бүтээгдэхүүн сүүнд шилжүүлснээр					
	3.2.1 Улсын дундаж		10.9 (2017 он)	12	14	
	3.2.1 Хот		7.2 (2017 он)	9	13	
	3.2.1 Хөдөө		15.5 (2017 он)	16	17	
4	Импортын сүүний нийт дотоодын сүүний хэрэглээнд эзлэх хувь	%	65 (2016 он)			-
5	Халдварт өвчнөөр өвчилсөн малын эдгэрэлтийн түвшин*	%	80.5 (2016 он)	85	95	ҮСХ (2017) Монгол улсын статистикийн эмхэтгэл-2016
6	Халдварт өвчний гаралтын тоо	Өвчин гарсан сумын тоо, давхардсан тоогоор	598 (2016 он)	300	150	
7	Нэг малын эмчид ногдох малын тоо	Мянган толгой мал	39.2 (2017 он)	30	25	Мал эмнэлэг үржлийн газар (2017) Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мал эмнэлэг, үржлийн газрын 2017 оны үйл ажиллагааны тайлан
<b>Гуравдугаар зорилт: Бэлчээр, усны нөөц баялгийг зохистой, хариуцлагатай ашиглах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох, түүний сөрөг нөлөөг бууруулахад хувь нэмэр оруулах</b>						
8	Бэлчээрийн даацаас хэтэрсэн малын тоо	Сая хонин толгой	25 (2017 он)	20	15	ХХААХҮЯ (2018.05.01) Бэлчээрийн тухай хуулийн төслийн танилцуулга
9	Үлийн цагаан оготно, царцаатай тэмцсэн талбайн нийт хохирол учирсан бэлчээрийн талбайд эзлэх хувь	%				ХХААХҮЯ (2017) Монгол мал" үндэсний хөтөлбөрийн хоёр дахь үе шатны ажлын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан
	7.1 Үлийн цагаан оготно		5.77 (2016 он)	8	10	
	7.2 Царцаатай		0.5 (2016 он)	1	1.5	
	7.3 Нийт		6.26 (2016 он)	9	11.5	

<b>Дөрөвдүгээр зорилт: Хөдөөгийн ядуурал, ажилгүйдэл, орлогын тэгш бус байдал бууруулах, нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах</b>						
	Нийгмийн даатгал төлсөн малчдын нийт малчдын тоонд эзлэх хувь	%	19.3 (2016 он)	40	60	ҮСХ (2018) www.1212.mn
	Хөдөөгийн ядуурлын түвшин	%	39.4 (2016 он)	30	20	ҮСХ (2017) Ядуурлын дүр төрх-2016 (Өрхийн нийгэм, эдийн засгийн 2016 оны судалгааны үр дүн)
	15-34 насны малчдын нийт малчдын тоонд эзлэх хувь	%	37.5 (2016 он)	40	40	ҮСХ (2017) Монгол улсын статистикийн эмхэтгэл-2016
	200-аас доош толгой малтай малчин өрхийн нийт малчин өрхийн тоонд эзлэх хувь	%	43 (2016 он)	30	20	ҮСХ (2017) Монгол улсын статистикийн эмхэтгэл-2016

### **Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр**

6. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 6.1. Улсын болон орон нутгийн төсвийн дэмжлэг;
- 6.2. Хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгө;
- 6.3. Олон улсын байгууллагын банк, санхүүгийн байгууллагын зээл, тусламжийн хөрөнгө;
- 6.4. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт;
- 6.5. Бусад эх үүсвэр.

### **Долоо. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ**

7.1. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад жил бүр хяналт-шинжилгээ, үр дүнд нь үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2017 оны 89 тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7.5 дахь заалтын дагуу хийнэ.

7.2. Хяналт-шинжилгээ, үр дүнд нь үнэлгээ хийх ажлыг мал аж ахуйн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.7-д заасны дагуу зохион байгуулж, тайланг Засгийн газрын хуралдаанд танилцуулна.

7.3. Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар үндэсний хөтөлбөрт хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

-----oOo-----